

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1. Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	8
3.4 Материаллаг байдал.....	8
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
3.5.1 Авлага.....	9
3.5.2 Урьдчилгаа.....	9
3.5.3 Бараа материал.....	9
3.5.4 Өр төлбөр.....	10
3.5.5 Засгийн газрын хувь оролцоо.....	10
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	12
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	15
4. Менежментийн захидал.....	15
4.1 Дансны авлагатай холбоотой асуудал.....	15
4.2 Дансны авлагатай холбоотой асуудал.....	15
4.3 Төсвийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой асуудал.....	16
4.4 Авлагын тооцоо нийлэлттэй холбоотой асуудал.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НХЭГ	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэх газар
НХА	Нийтийг хамарсан ажил
НББ	Нягтлан Бодох Бүртгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТБ	Төрийн бус байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ДАШДЭМБЭРЭЛ
ТАНАА

2021.03.25 № 01/1010
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 77.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Дансны авлагын үлдэгдэлд насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан 20,350.3 сая төгрөгийн авлагатай, 987.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
 - Авлагын дансны үлдэгдэл, бодит үлдэгдлээс 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэсэн;
 - Аймаг, нийслэлийн дэд сангуудад төсөв хуваарилаагүй байхад төсвийн жилийн дундуур "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж" баталж хэрэгжүүлснээс, төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн зарчим зөрчигдөн, ХЭДС-ийн үндсэн данснаас, нэмэлт санхүүжилтийн данс руу 987.4 сая төгрөгийн шилжүүлэн зарцуулсан
- зэрэг нь Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, тохиолдсон байх, эрх үүрэг, иж бүрэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	186,669,162.8	192,858,535.7
33	АВЛАГА	186,633,375.7	192,839,158.2
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	145.3	48.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	96,656,375.1	100,924,350.3
33400	Зээлийн хүүгийн авлага	56,929.3	79,324.2
33500	Бусад авлага	3,914,977.6	4,228,970.2
33600	Зээлийн авлага	86,004,948.4	87,606,465.5
34	УРЬДЧИЛГАА	35,787.1	17,355.0
35	БАРАА МАТЕРИАЛ	-	2,022.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	186,669,162.8	192,858,535.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,543,518.0	36,514,227.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,328,582.5	20,531,780.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	7,715.2	1,612,130.3
41300	Өглөг	98,417.2	675,167.0
41400	Урьдчилж орсон орлого	22,222,450.1	18,244,483.5
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	22,222,450.1	18,244,483.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,214,935.6	15,982,447.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	156,125,644.7	156,344,308.0
51	Засгийн газрын хувь оролцоо	156,125,644.7	156,344,308.0
51200	Хуримтлагдсан үр дүн	156,125,644.7	156,344,308.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	186,669,162.8	192,858,535.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	63,677,026.6	59,253,759.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,452,582.1	38,804,578.9
120	Нийтлэг татварын бус орлого	54,452,582.1	38,804,578.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,224,444.5	20,449,180.1
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,100,000.0	20,330,238.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,444.5	118,941.7
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,000.0	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	33,879,406.8	58,647,427.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,879,406.8	58,647,427.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,250.8	907,404.9
2104	Хангамж, бараа материалын зардал	23,220.0	350,914.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,268.8	144,694.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,762.0	411,795.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,616,156.1	57,740,022.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,616,156.1	57,740,022.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	29,797,619.8	606,331.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	214,935.6	367,709.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	29,582,684.2	238,622.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	160,493,991.0	211,186,991.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,857,271.0	166,207,460.1
120	Нийтлэг татварын бус орлого	117,857,271.0	166,207,460.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	42,636,720.0	44,979,531.6
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	34,450,000.0	30,311,222.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,086,720.0	14,668,309.4
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	100,000.0	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152,493,991.0	208,962,491.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,493,991.0	208,962,491.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,565.9	2,192,427.4
2104	Хангамж, бараа материалын зардал	23,220.0	22,838.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205,308.4	303,074.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,037.5	1,866,514.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	152,168,425.1	206,770,064.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,512,050.1	86,881,441.6
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	96,656,375.1	100,924,350.3
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	18,964,272.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,000,000.0	2,224,500.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(8,000,000.0)	(2,224,500.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	8,000,000.0	2,224,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	126,474,786.4		126,474,786.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	68,174.1		68,174.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	126,542,960.5		126,542,960.5
Тайлант үеийн үр дүн	29,582,684.2		29,582,684.2
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,125,644.7		156,125,644.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(19,959.3)		(19,959.3)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,105,685.4		156,105,685.4
Тайлант үеийн үр дүн	238,622.6		238,622.6
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,344,308.0		156,344,308.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,014,209,000.00	68,901,544,338.64	(20,112,664,661.36)	77.4
УРСГАЛ ЗАРДАЛ	81,599,209,000.00	66,677,044,338.64	(14,922,164,661.36)	81.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000,000.00	110,788,221.73	(87,211,778.27)	56.0

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000,000.00	110,788,221.73	(87,211,778.27)	56.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,401,209,000.00	66,566,256,116.91	(14,834,952,883.09)	81.8
Бусад урсгал шилжүүлэг	81,401,209,000.00	66,566,256,116.91	(14,834,952,883.09)	81.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,401,209,000.00	66,566,256,116.91	(14,834,952,883.09)	81.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨР-ИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	7,415,000,000.00	2,224,500,000.00	(5,190,500,000.00)	30.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	7,415,000,000.00	2,224,500,000.00	(5,190,500,000.00)	30.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,014,209,000.00	156,158,460,311.39	67,144,251,311.39	175.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,889,179,000.00	20,330,238,400.00	(7,558,940,600.00)	72.9
Улсын төсвөөс санхүүжих	27,889,179,000.00	20,330,238,400.00	(7,558,940,600.00)	72.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	61,125,030,000.00	135,828,221,911.39	74,703,191,911.39	222.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,213,627,000.00	26,523,339,487.40	4,309,712,487.40	119.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,300,000,000.00	8,339,107,560.70	7,039,107,560.70	641.5
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,196,403,000.00	93,550,774,863.29	63,354,371,863.29	309.8
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,415,000,000.00	7,415,000,000.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,668,309,358.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,668,309,358.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	837,317,844.08
2104	Хангамж, бараа материалын зардал	22,838,000.00
210401	Бичиг хэрэг	22,838,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,685,319.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,055,382.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	51,629,937.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	663,794,525.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	394,893,825.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	268,900,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,830,991,513.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,242,280,526.65
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,242,280,526.65
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,588,710,987,270.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,591,596,095.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	997,114,892.27
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,668,309,358.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,668,309,358.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,135,003,808.00
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,413,248,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,057,450.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн төлөвлөлт, санхүүжилт, авлагын эргэн төлөлтийг сайжруулах, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах Сангийн сайдын тушаал, журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 10-наас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж гүйцэтгэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02/84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа буюу хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг санхүүжүүлдэг сан юм. Сангийн эрхэм зорилгыг хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулах гэж тодорхойлжээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Иргэний хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын жишигт нийцүүлэн мэргэжлийн боловсрол, үр чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн

- харилцааны соёл төлөвшүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлж, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох.
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшнийг бууруулах.
 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн нэгдсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, бодлогын загварчлал боловсруулах, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг орчин үеийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулах, хөгжүүлэх.
 - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод, нээлттэй болгож, хяналтыг сайжруулах.
 - Бодлогын хэрэгжилтийн явц, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу 2019 оны 12 дугаар сард шинэчлэгдсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газар 2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа 36 байгууллагад хяналт шалгалт хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 120 зөвлөмж өгч, бүрэн хэрэгжсэн гэж тайлагнасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар ирүүлсэн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 82,509.4 сая төгрөгийн 1.0 хувь буюу 825.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 59,015.1 сая төгрөг байгааг үндэслэн материаллаг байдлын түвшнийг 590.1 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 186,633.4 сая, эцсийн үлдэгдэл 192,839.2 сая төгрөг болж, 6,205.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 **Авлагын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	0.0	(0.1)
Татаас, санхүүжилтийн авлага	96,656.4	100,924.4	4,268.0
Зээлийн хүүгийн авлага	56.9	79.3	22.4
Бусад авлага	3,915.0	4,229.0	314.0
Байгууллагаас авах авлага	3,032.9	3,028.1	(4.8)
Хувь хүмүүсээс авах авлага	882.0	1,200.9	318.8
Зээлийн авлага	86,004.9	87,606.5	1,601.5
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	78,004.9	77,382.0	(623.0)
Хувь хүмүүст олгосон зээл	44,185.0	44,152.0	(33.0)
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	33,819.9	33,230.0	(590.0)
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	8,000.0	10,224.5	2,224.5
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	8,000.0	10,224.5	2,224.5
Нийт дүн	186,633.4	192,839.2	6,205.8

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага тайлант онд 6,205.8 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 27,348.7 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 7,025.1 сая, Дэлхийн банкнаас олгосон жижиг зээлийн санхүүжилтийн үлдэгдэл 2,115.0 сая нийт 36,488.8 сая төгрөгөөр нэмэгдэж, жижиг зээлийн эргэн төлөлт 25,350.0 сая, ажлын байрны төлбөрийн урьдчилж орсон орлого 5,368.1 сая, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлого 1,485.8 сая, бусад орлого 16,9 сая, нийт 32,220.8 сая төгрөгөөр хасагдаж, 4,268.0 сая төгрөгөөр татаас санхүүжилтийн авлага нэмэгдсэн;
- ХААН болон Төрийн банкнаас авах жижиг зээлийн хүүгийн авлага 22.4 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Байгууллага, хувь хүмүүсээс авах авлага тайлант онд олгосон санхүүгийн дэмжлэг олгосноор 314.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлээс 2013 оны авлага болох Оёдлын холбооноос 590.0 сая, хувь хүнд олгосон зээлээс 33.0 сая нийт 623.0 сая төгрөгийн авлагыг барагдуулсан;
- 2020 онд жижиг зээлийг ХААН банкинд 1,132.6 сая, Төрийн банкинд 1,091.9 сая нийт 2,224.5 сая төгрөгийг дамжуулан олгосон байна.

3.5.2 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 35.8 сая, эцсийн үлдэгдэл 17.4 сая төгрөг болж, 18.4 сая төгрөгөөр буурсан байна. Дархан Уул аймгийн ХЭДС 23.0 сая, Говь алтай аймгийн ХЭДС 12.8 сая төгрөгийн урьдчилгааг хааж, тайланд онд Нийслэлийн ХЭГ 9.4 сая, Налайх дүүргийн ХЭДС 6.8 сая, Дорноговь аймгийн ХЭДС 1.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэлгүй, Ховд аймгийн ХЭДС-д түлш, шатах тослох

материал 0.7 сая, бусад хангамжийн материал 1.3 сая, нийт 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.4 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 30,543.5 сая, эцсийн үлдэгдэл 36,514.2 сая төгрөг болж, 5,970.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 **Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат зээлийн өглөг	7.7	1,612.1	1,604.4	4.4
Төгрөг	7.7	1,612.1	1,604.4	4.4
Хувь хүмүүст олгосон зээл	7.7	1,612.1	1,604.4	4.4
Өглөг	98.4	675.2	576.7	1.8
Ажилчидтай холбогдсон өглөг	1.0	5.4	4.4	0.0
Зээлийн хүүгийн өглөг	34.1	74.2	40.1	0.2
Бусад өглөг	63.3	595.5	532.3	1.6
Байгууллагад төлөх өглөг	49.9	200.0	150.1	0.5
Хувь хүмүүст төлөх өглөг	13.4	395.5	382.1	1.1
Урьдчилж орсон орлого	22,222.5	18,244.5	(3,978.0)	50.0
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	22,222.5	18,244.5	(3,978.0)	50.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,214.9	15,982.4	7,767.5	43.8
Урт хугацаат зээл	8,214.9	15,982.4	7,767.5	43.8
Төгрөг	8,214.9	15,982.4	7,767.5	43.8
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	8,214.9	15,982.4	7,767.5	43.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,543.5	36,514.2	5,970.7	100.0

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөр тайлант онд 5,970.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дараах шалтгаантай байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт олгох улсын төсвийн санхүүжилт дутуугаас хувь хүмүүст олгосон зээлийн үлдэгдэл 1,604.4 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Зээлийн хүүгийн өглөг нь ХНХЯ, Сангийн яам, ХХҮЕГ 3 талт гэрээний хүрээнд Дэлхийн банкнаас олгосон жижиг зээлийн санхүүжилтэд тооцсон хүүгийн зардал 40.1 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Урьдчилж орсон орлого буюу ажлын байрны төлбөрийн орлого оны эхэнд 22,222.5 сая төгрөг байснаас тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрсөн болон буцаасан дүнгээр буурч, 2020 оны орсон 17,913.4 сая төгрөг орлого, ажлын байрны буцаалтад олгохоор тооцсон 331.1 сая нийт 18,244.5 сая төгрөгийн үлдэгдэл байна.
- Дэлхийн банкны санхүүжилтээр арилжааны банкаар дамжуулан олгох жижиг зээлд 7,415.0 сая, валютын ханшны зөрүү 352.5 сая нийт 7,767.5 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр нэмэгдсэн байна.

3.5.5 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 156,125.6 сая, эцсийн үлдэгдэл 156,344.3 сая төгрөг болж, 218.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 **Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын хувь оролцоо	156,125.6	156,344.3	218.7	100.0
Хуримтлагдсан үр дүн	156,125.6	156,344.3	218.7	100.0

Өмнөх үеийн үр дүн	126,543.0	156,105.7	29,562.7	99.8
Тайлант үеийн үр дүн	29,582.7	238.6	(29,344.1)	0.2
Дүн	156,125.6	156,344.3	218.7	100.0

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 156,344.3 сая төгрөг болж 218.7 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгийн өсөлтөөс шалтгаалж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 119,337.3 сая төгрөгөөр, урсгал зарлагыг 119,337.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26,176.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 145,514.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор 56,499.8 сая төгрөгөөр бууруулж, 89,014.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 89,014.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 89,014.2 сая төгрөгийг нийт зарлага ба цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын эх үүсвэрийн 27,889.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 22,213.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 1,300.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 30,196.4 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс /татаас санхүүжилтийн авлага/, 7,415.0 сая төгрөгийг гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 20,330.2 сая, гадаад эх үүсвэрээс 7,415.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 26,523.3 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 8,339.1 сая төгрөгийн тус тус бүрдүүлж, 93,550.8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Улсын төсвөөс 7,558.9 сая төгрөг дутуу санхүүжүүлж, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагаас 93,550.8 сая төгрөг барагдсан байна.

Гадаадын иргэд ажиллах зөвшөөрөл авахын тулд 2021 оны төлбөрийг урьдчилж төлснөөр ажлын байрны төлбөрийн орлого нэмэгдэж үндсэн үйл ажиллагааны орлого 4,309.7 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагын судалгаа гаргаж, албан шаардлага өгч ажилласнаар туслах үйл ажиллагааны орлого 7,309.1 сая төгрөгөөр давсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 68,901.5 сая төгрөг буюу 77.4 хувьтай байгаа нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 14,834.9 сая, гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл 5,190.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 87.2 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 4,135.0 сая, Засгийн газрын нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 100.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө 10,413.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20.1 сая нийт 14,668.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэмж, урамшуулалд 10,242.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 663.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 150.7 сая, хангамж, бараа материалын зардалд 22.8 сая, орон нутгийн төсвийн захирагчдад 997.1 сая төгрөг шилжүүлж нийт 12,076.7 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 2,591.6 сая төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Салбарын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 5066 мэдээллээс 4383 мэдээллийг хугацаанд нь, 605 мэдээллийг хугацаа хоцроож, 78 мэдээллийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 34.7 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 23,189.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, 7,293.9 сая төгрөгийн 24 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	7	34.7	7	34.7			100.0
Албан шаардлага	10	23,189.1	7	6,226.2	3	16,962.9	26.8
Зөвлөмж	24	7,293.9	24	7,293.9			100.0
Нийт	41	30,517.7	38	13,554.8	3	16,962.9	44.4

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 35 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудад “Зөрчилгүй” 24, “Хязгаарлалттай” 7 /Нийслэлийн Хөдөлмөр эрхлэх газар, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур, Налайх дүүргийн ХЭДС/ дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 104,743.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 77,353.1 сая төгрөгийн 48 алдааг аудитын явцад залруулж, 239.4 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 2,220.0 сая төгрөгийн 27 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 24,930.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 52 зөвлөмжийг хүргүүлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн 76,091.8 сая төгрөгийн зөрүүг залруулав. Үүнд:

- *Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд* татаас санхүүжилтийн авлагыг 46.7 сая төгрөгөөр дутуу, хуримтлагдсан үр дүнг 46.7 сая төгрөгөөр илүү нэгтгэсэн;
- *Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд* төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг 8,752.7 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 1,464.7 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 443.6 сая, хангамж, бараа материалын зардал 218.2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.3 сая төгрөгөөр тус тус дутуу, улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг 8,374.6 сая, Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих орлого 1,860.1 сая, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг 380.7 сая, улсын төвлөрсөн төсвөөс олгосон шилжүүлэг 45.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 0.3 сая, бусад урсгал шилжүүлэг 0.2 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- *Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд* төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг 7,983.1 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 1,125.5 сая, нийтлэг татварын бус орлого 440.4 сая, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох төвлөрүүлэх шилжүүлэг 154.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1.0 сая төгрөгөөр тус тус дутуу, улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг 8,137.3 сая, Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих 1,519.8 сая, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондыг шилжүүлэг 45.0 сая, бараа үйлчилгээний бусад зардал 9.7 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- *Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд* оны эхний үлдэгдэл 1,427.3 сая төгрөгөөр илүү, өмнөх оны тайлант үеийн үр дүн 8,120.9 сая, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 3.5 сая, тайлант оны үр дүн 188.8 сая, эцсийн үлдэгдэл 6,885.9 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- *Төсвийн гүйцэтгэлийн тайланд* төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 4,502.4 сая, бусад урсгал шилжүүлэг 4,385.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 13.7 сая төгрөгөөр тус тус дутуу, улсын төсвөөс санхүүжих орлоог 6,966.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 196.6 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- *Нэмэлт санхүүжилтийн тайланд* 1,773.3 сая төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого, 545.1 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас, санхүүжилт, 3.6 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж тус тус дутуу, 16.2 сая төгрөгөөр төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг, 7.9 сая төгрөгөөр улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг, 2.7 сая төгрөгөөр бараа ажил үйлчилгээний бусад зардал, 2.1 сая төгрөгөөр бусад урсгал шилжүүлэг тус тус илүү нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Тайлант онд гадаад иргэдийн ажлын байрны төлбөр 26,266.4 сая төгрөгийн орлого орж, 1,823.3 сая төгрөгийн гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн буцаалт хийгдсэн байна. Ажлын байрын төлбөрийн орлогын бүртгэл, буцаалтад тавих хяналт хангалтгүй, буцаалт хийсэн баримтын бүрдэл дутуу, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцааг зохицуулах үйлчилгээний бүртгэл мэдээллийн программ хангамжийн шинэчлэл удаашралтай байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах

үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 5066 мэдээллээс 4383 мэдээллийг хугацаанд нь, 605 мэдээллийг хугацаа хоцроож, 78 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.9-т заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3. ХЭДС-ийн харьяа зарим байгууллагуудын нягтлан бодогчид нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, зарчмыг баримтлаагүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн.

4. ХЭДС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг буруу нэгтгэсэн, батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 1.2-т "Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан /цаашид төсвийн ерөнхийлөн захирагч гэх/ гаргахад УСНББОУС 6 "Нэгтгэсэн тайлан болон тусдаа санхүүгийн тайлан гэсэн стандарт болон энэхүү журмыг мөрдөнө", 2.3-т "Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр /мянга, сая төгрөгөөр/ илэрхийлэгдсэн байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн.

Төвлөрүүлэн захирагч болон харьяа түүврээр хамрагдсан төсвийн шууд захирагчдад өгсөн 23,728.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4,921.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,261.3 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 239.4 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,220.0 сая төгрөгийн 24 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,180.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 47 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон жижиг зээл, түүнд батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийн сангийн ашиглалт, нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хийсэн дотоод хяналт шалгалтын үр дүн, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авсан эсэхэд дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Дансны авлагатай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Дансны авлагын үлдэгдэлд насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан 20,350.3 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Авлага бууруулах арга хэмжээ хангалтгүй, сангийн авлагын эргэц удааширснаас хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж буурах

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг тооцож, ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.2 Дансны авлагатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

ХХААЯ-наас авах авлагын дансны үлдэгдэл, бодит үлдэгдлээс 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Авлагыг нотлох баримт, тооцоо нийлсэн актад үндэслэн бүртгээгүй, санхүүгийн тайлан буруу дүнгээр илэрхийлэгдэх,

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулан, санхүүгийн тайланд зөв дүнгээр илэрхийлэх,

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.3 Төсвийн төлөвлөлт, санхүүжилттэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

Аймаг, нийслэлийн дэд сангуудад төсөв хуваарилаагүй байхад төсвийн жилийн дундуур "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж" баталж хэрэгжүүлснээс, төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн зарчим зөрчигдөн, ХЭДС-ийн үндсэн данснаас, нэмэлт санхүүжилтийн данс руу 987.4 сая төгрөгийн шилжүүлж зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журмын 3-т "Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрхийг олгоход баримтлах зарчим" 3.1-т "Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрх нь тухайн байгууллагын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт нийцсэн байна", 3.2-т "Төсвийн тухай хуулийн 12.1.17, 34.3-т заасны дагуу төрийн сан нь төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан төсвийн санхүүжилтийн эрхийг доорх дарааллыг баримтлан олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Төсвийн жилийн дундуур төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд өөрчлөлт оруулах, төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх зөрчигдөх,

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, санхүүжилтийн зарчмыг мөрдөж ажиллах,

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.4 Авлагын тооцоо нийлэлттэй холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт:

ХЭДС-ийн авлага өмнөх оноос 6,104.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 148,180.9 сая төгрөгийн авлагатай байгаагийн 987.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.4.2 Эрсдэл:

Авлага, өр төлбөр бодитой биш байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулж, тайлан бүртгэлд тусгаж байх

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020 он	Аудитын нэр:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Аудитын код: САГ-2021/17/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
1	Тайлант онд гадаад иргэдийн ажлын байрны төлбөр 26.266.4 сая төгрөгийн орлого орж, 1,823.3 сая төгрөгийн гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн буцаалт хийгдсэн байна. Гадаад ажиллах хүч, мэргэжилтэн авах хэлтсийн ажлын байрны төлбөрийн орлогын бүртгэл, буцаалтад тавих хяналт сул, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцааг зохицуулах үйлчилгээний бүртгэл мэдээллийн программ хангамжийн шинэчлэл удаашралтай байна.		Албан шаардлага	Дарга СТГ-ын дарга АХШХГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, З.Буянбадрах Ж.Мөнхтуяа
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 5066 мэдээллээс 4383 мэдээллийг хугацаанд нь, 605 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 78 мэдээллийг байршуулаагүй байна.		Албан шаардлага	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
3	ХЭДС-ийн харьяа зарим байгууллагуудын нягтлан бодогчид нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, зарчмыг баримтлаагүйгээс санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж; хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна.		Албан шаардлага	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
4	ХЭДС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй байна		Албан шаардлага	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
5	Дансны авлагын үлдэгдэлд насжилт өндөртэй, эргэн төлөлт удааширсан 20.350.3 сая төгрөгийн авлага байна.	20,350.3	Албан шаардлага	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
6	ХХААЯ-наас авах авлагын дансны үлдэгдэл, бодит үлдэгдлээс 1,403.6 сая төгрөгөөр илүү бүртгэлтэй байна.	1,403.6	Зөвлөмж	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
7	Аймаг, нийслэлийн дэд сангуудад төсөв хуваарилаагүй байхад төсвийн жилийн дундуур "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж" баталж хэрэгжүүлснээс, төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн зарчим зөрчигдөн,	987.4	Зөвлөмж	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа

	ХЭДС-ийн үндсэн данснаас, нэмэлт санхүүжилтийн данс руу 987.4 сая төгрөгийг шилжүүлж зарцуулсан.				
8	ХЭДС-ийн авлага өмнөх оноос 6,104.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 148,180.9 сая төгрөгийн авлагатай байна. Нийт авлагаас 987.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	987.5	Зөвлөмж	Дарга СТГ-ын дарга ХЭДС хариуцсан мэргэжилтэн	Л.Дашдэмбэрэл Д.Билэгмаа, Ж.Мөнхтуяа
3	Архангай аймаг ХЭДС				
1	Санхүүгийн тайланд тусгасан авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй.	635.5	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Т.Тамир, Д.Цэнд-Аюуш
2	Татаас санхүүжилтийн авлагын үлдэгдлийг ХХҮЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу төвлөрүүлснээр журналын бичилт хийж авлагыг бууруулсан.	65.8	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Т.Тамир, Д.Цэнд-Аюуш
3	НББ-ийн бодлогын баримт бичгийг бүрэн мөрдөж ажиллаагүй.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Т.Тамир, Д.Цэнд-Аюуш
4	Шилэн дансанд 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Т.Тамир, Д.Цэнд-Аюуш
	Баян-Өлгий аймаг ХЭДС				
1	Шилэн дансны цахим хуудсанд 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Б.Съезхан, Т.Фарида
	Баянхонгор аймаг ХЭДС				
1	Хонгорын багачууд ТББ болон Гурванбулаг сумын ЗДТГ-ын дарга нь аймгийн ХХҮГ-ын даргатай гэрээ байгуулан НХА зохион байгуулсан ба байнгын ажлын байртай 2 хүнд тус бүр 252.0 мянга, Гурванбулаг сумын 3-р багийн Засаг даргад 201.6 мянган төгрөг, нийт 705.6 мянган төгрөгийн цалинг бодож олгосон байна.	0.7	төлбөрийн акт	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүд	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг, А.Өлзийжаргал, Д.Алтангоо, Б.Тунгалагтамир
2	Шилэн дансны цахим хуудсанд орлогын 9 гүйлгээ, зарлагын 46 гүйлгээ, нийт 1,622,793.6 мянган төгрөгийн 55 гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй	-	Албан шаардлага	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг
3	Тайлант оны НХА зохион байгуулах зардлыг түүвэрлэн үзэхэд байнгын ажлын байраар хангагдсан иргэдэд цалин олгосон зөрчил илэрсэн	-	Зөвлөмж	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг
4	Тайлант хугацааны ажилд зуучлах үйлчилгээний нэг хүнд ногдох зардлыг ХНХС-ын 2019 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээтэй тулган баталгаажуулахад 610.0 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байна.	0.6	Зөвлөмж	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг
5	ЖДҮХС-аас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага ХЭДС-ийн зээлийг давхардуулан авсан байна. Тухайлбал: 2019 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөс 2 иргэн 8000.0 мянган төгрөг, 2020 онд 1 иргэн 3000.0 мянга, 2019 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес эрхлэх хөтөлбөрөөс 1 иргэн 9375.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 1 иргэн 1500.0 мянган төгрөг, 2017 онд ХЭДС-ийн жижиг зээлд 1 иргэн хамрагдаж 8500.0 мянган төгрөгийг тус тус давхардуулан авсан байна.	30.4	Зөвлөмж	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг

6	Баянхонгор аймгийн ИТХТ-ийн 2020 оны 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн эзэн" аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж, үр дүнтэй хэрэгжүүлсэн хавсралтад заасан 295 өрхийн орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 2017, 2018, 2019 онд санхүүжүүлсэн 287,600.0 мянган төгрөгийн авлагыг чөлөөлж, хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гарсан ч тухайн байгууллагын дарга холбогдох шийдвэрийг гаргаж ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн авлагыг бууруулаагүй байна.	287.6	Зөвлөмж	Дарга, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	Д.Амарсанаа, Д.Алтанцэцэг
Булган аймаг ХЭДС					
1	Тайлант онд 79707.2 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн.	79.7	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Батжаргал, П.Ундармаа
Говь-Алтай аймаг ХЭДС					
1	Зээлийн гэрээ дуусаагүй зээлдэгч нартай холбоотой 3,605.4 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна.	3.6	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
2	Тайлант хугацаанд оруулбал зохих 113 мэдээллээс хугацаандаа оруулсан 102 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 15 хугацаа хоцроосон, 11 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.	-	Албан шаардлага	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
3	Зээлийн гэрээ дууссан зээлдэгч нартай холбоотой 2,700.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлүүлээгүй байна.	2.7	Төлбөрийн акт	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Мянганбуу, Л.Удвал
Говьсүмбэр аймаг ХЭДС					
1	ХНХЯ-аас тус сангийн батлагдсан төсөвт 4 удаа өөрчлөлт оруулж 316,715.0 мянган төгрөгийн санхүүжилт хасагдсан боловч жилийн эцэст батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгогдсоныг сүүлийн төсвийн хуваарьтай тулган баталгаажуулаагүй.	1.6	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Х.Буянбаяр, Т.Батсайхан
Дархан-Уул аймаг ХЭДС					
1	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулахдаа ХЭҮЗ-ийн баталсан тогтоолыг зөрчин илүү зарцуулсан.	0.7	Албан шаардлага	Дарга, сангийн мэргэжилтэн	С.Энхболд, Б.Гэрэлтзам
2	Шилэн дансны цахим хуудсанд нийт 5 мэдээллийг 4,6,8 дугаар сард хугацаа хоцрон байршуулсан.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Энхболд, Б.Гэрэлтзам
Дорноговь аймаг ХЭДС					
1	Тайлант онд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 8,500.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр 148,734.6 мянган төгрөг төвлөрсөн байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Цэндмаа, Т.Аззаяа
2	Тайлант оны төсөвт 4 удаагийн тодотгол хийгдэж, батлагдсан төсвөөс 119,557.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч 91,144.2 мянган төгрөгийн хөтөлбөрийн өглөг үүссэн байна.	91.4	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Цэндмаа, Т.Аззаяа
Дорнод аймаг ХЭДС					
1	Шилэн дансны цахим хуудсанд батлагдсан төсөв, төсвийн төсөл, санхүүгийн хагас жилийн тайлан, төсөл хөтөлбөртэй холбоотой 776,307.8 мянган төгрөгийн мэдээллийг оруулаагүй байна.	776.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	А.Мягмарсүрэн, Б.Золзаяа

	Дундговь аймаг ХЭДС				
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Хишигдаваа, Э.Одонтуяа
	Орхон аймаг ХЭДС				
1	Өмнөх оны аудитаар 2017 онд олгосон 18,908.0 мянган төгрөгийн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэлтэй иргэн, аж ахуйн нэгжээс зээлийн төлбөрийг бүрэн барагдуулах зөвлөмж өгсөн боловч бүрэн барагдуулаагүй 13,398.4 мянган төгрөг байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Х.Эрдэнэбат, О.Саранчимэг
2	2015 онд олгогдсон "Хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл хоршоо байгуулах иргэний дэмжих хөтөлбөр"-ийн 7 иргэний 4,260.9 мянган төгрөг, "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 иргэний 4,760.0 мянган төгрөг, нийт 9,020.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Х.Эрдэнэбат, О.Саранчимэг
	Өвөрхангай аймаг ХЭДС				
1	Худалдаж авсан програм хангамжийг байгууллагын санхүүгийн програм хангамжид бүртгээгүй	6.5	Албан шаардлага	Нягтлан бодогч	Б.Болд
	Өмнөговь аймаг ХЭДС				
1	Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж		
	Сүхбаатар аймаг ХЭДС				
1	ХЭҮЗ-ийн 2017-2020 оны тогтоолын хавсралтаар батлагдсан тухайн хөтөлбөр, хамтран ажиллах гэрээний холбогдох заалтын дагуу санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг төлж барагдуулаагүй.	210.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах, Э.Улаанхүүхэн
2	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хамрагдсан иргэдийн 200,000.0 мянган төгрөгийн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлээгүй, гэрээнд заасан хугацааны дагуу дотоод хяналт хийгдсэн ч үр дүнг тооцож ажиллаагүй.	200.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах, Э.Улаанхүүхэн
3	ХЭДС хэрэгжүүлж байгаа дотоод хяналт үр нөлөөгүй байна. Тухайлбал ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд тодорхой шийдэл гаргаагүй, удирдлагыг зөв зохистой мэдээллээр хангаагүйгээс санхүүгийн дэмжлэгийн хөрөнгө төлөвлөсөн хугацаандаа төвлөрөөгүй, мөн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнгээ өгөөгүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Д.Гэрэлбадрах, Э.Улаанхүүхэн
	Сэлэнгэ аймаг ХЭДС				
1	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан.	2.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Л.Зоригтбаатар, Д.Наранцэцэг
	Төв аймаг ХЭДС				
1	Шатахуун олгохдоо суудлын авто машины замын хуудсаар шатахууныг бодож олгоогүй 2159.3 мянган төгрөгийн алдаа гаргасан байна.	2.1	Зөвлөмж	нягтлан бодогч	Б.Цолмон
	Ховд аймаг ХЭДС				

1	Гөү Окей ХХК-тай гэрээ байгуулан Санхүүгийн дэмжлэгийн модуль боловсруулах зорилгоор програм хангамжид нэмэлт сайжруулсан. Эв эе эвийн хүч худалдааны төвд "Залуучуудын үйлдвэрлэсэн бараа, бүтээдэхүүнийг борлуулах цэг" байгуулахад үндсэн хөрөнгө, БҮТЭЗ худалдан авч данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан.	9.1	Зөвлөмж	ХХҮГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
2	Шатахуун түгээх байгууллагатай хамтран ажиллах гэрээнд зааснаар урамшуулалд олгосон шатахууныг орлогод аваагүй, 2020 онд ХЭДС-аас шатахууны зардалд зарцуулсан, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, зарцуулалтад тавих дотоод хяналт сул байна.	12.2	Зөвлөмж	ХХҮГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
3	Төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа зээлдэгчид нь Монгол банкны мэдээллийн санд оруулаагүйгээс сумдын СХС болон бусад хэлбэрээр зээл авсан иргэнд давхардуулан зээл олгосон.	41.0	Зөвлөмж	ХХҮГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
4	ХЭДС-ийн үйл ажиллагаатай холбоотой албан хаагчдад сургалт зохион байгуулахдаа ажилчдад бичиг хэрэг, үдийн хоол өгөх зэрэгт хөрөнгө зарцуулсан нь сангийн хөрөнгийг үр өгөөжийг бууруулж байна.	7.2	Зөвлөмж	ХХҮГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
6	Жаргалант сумын хэмжээнд ХНА-д ажилгүй иргэдийг хамруулан түр ажлын байранд ХХҮГ-аас ирүүлсэн жагсаалтад байгаа хүмүүс дээр нэмж сумын 12 багуудаас ажилгүй хүмүүсийг бүртгэхдээ Хот тохижилтын нягтлан бодогч, нярав нь өөрийн хамаарал бүхий этгээдийг бүртгэсэн боловч тухайн хүмүүс нь ажиллаагүй, ААНБ-д ажилладаг хүмүүс ажиллуулж цалин олгодог гэсэн мэдээлэл иргэдийг бухимдуулж байгаа нь тухайн НХА-ын явцын хяналт хэрэгжүүлээгүй, ажилласан ажиллаагүй нотлох баримтгүй байна.	-	Зөвлөмж	ХХҮГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Билэгдэмбэрэл, Т.Сайнбаяр
Хөвсгөл аймаг ХЭДС					
1	ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөрөөр олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх хугацааг харгалзахгүй богино хугацаат авлагаар бүртгэж тайлагнасан байна.	-	Зөвлөмж	Дарга	Б.Эрдэнэхуяг
2	Шилэн дансны цахим хуудсанд 147 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.	-	Зөвлөмж	Дарга	Б.Эрдэнэхуяг
Хэнтий аймаг ХЭДС					
1	Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хангалтгүй хийгдсэн байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Эрдэнэжаргал, Д.Ганшуурга
Нийслэлийн ХЭГ					
1	1. Шилэн дансны цахим хуудсанд сангийн дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчилж, өөрчлөөгүй, 12 удаагийн мэдээ хожимдуулж, 35 удаагийн мэдээ байршуулаагүй, 29 удаагийн / 2,879,981.0 мянган төгрөг / орлого, зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
2	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг холбогдох баримтуудтай тулган шалгахад 9,759.0 мянган төгрөгийн авлага үлдэгдэлтэй бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, он дамжсан авлага байна.	9.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва

3	Авлагын үлдэгдлээс шүүхийн байгууллагад шилжүүлж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	9.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
4	Нийт 3 байгууллагатай холбоотой өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээр Газрын даргын 2020-12-30 А/43 тушаалаар хаасан байна.	13.1	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
5	Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүнг нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнтэй тулгахад 42 байгууллагад 24,551.9 мянган төгрөгөөр илүү, худал-дан авалт 7 байгууллагын дүн 12,593.9 мянган төгрөгөөр дутуу байна.	37.1	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
6	Нийт 4 байгууллагад 9,396.0 мянган төгрөгийг гэрээний заалтыг баримтлахгүй урьдчилан шилжүүлсэн байна.	9.4	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
7	Ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний батлагдсан зардлыг 6.1 мянган төгрөгөөр, цагийн ажилд зуучлах 1 хүний батлагдсан жишиг нормыг 20.3 мянган төгрөгөөр буюу 23,482.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	44.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Нямдорж, Т.Лхагва
Баянгол дүүрэг ХЭДС					
1	Хөтөлбөрөөс иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгийн гэрээний хугацаа дууссан боловч эргэн төлөгдөөгүй авлагын үлдэгдэлтэй байгаа зөрчил	228.8	Албан шаардлага	Дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч	Ж.Очирхүү, М.Дуламжав, З.Ганцэцэг
2	Хүчин төгөлдөр анхан шатны баримт буюу цахим төлбөрийн баримтаар нотлогдохгүй зарлагын гүйлгээ гаргасан зөрчил	78.7	Зөвлөмж	ХЭДС хариуцсан мэргэжилтэн	З.Ганцэцэг
3	Зардлыг аккруэл сууриар тайлагнаж бүртгээгүй зөрчил	38.4	Зөвлөмж	ХЭДС хариуцсан мэргэжилтэн	З.Ганцэцэг
4	Шилэн дансны цахим хуудсанд огт мэдээлээгүй 2, хугацаандаа мэдээлээгүй 59 мэдээлэл байна.	-	Албан шаардлага	ХЭДС хариуцсан мэргэжилтэн	З.Ганцэцэг
5	Ажлын хөлснөөс хуулийн дагуу НДШ тооцон суутгаж, төсөвт шилжүүлээгүй зөрчил	20.9	Зөвлөмж	ХЭДС хариуцсан мэргэжилтэн	З.Ганцэцэг
6	Хөтөлбөрийн гэрээт ажилчдын цалин хөлсийг гэрээнд тусгагдсан гүйцэтгэлийг тодорхойлох анхан шатны баримтыг бүрдүүлээгүйгээр тооцож олгосон зөрчил	9.6	Зөвлөмж	ХЭДС хариуцсан мэргэжилтэн	З.Ганцэцэг
Баянзүрх дүүрэг ХЭДС					
1	Шилэн дансны мэдээлэлд " төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага " үүсгэсэн тушаал шийдвэрийг оруулаагүйгээс 851,088.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн	-	Зөвлөмж	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Л.Цолмонгэрэл, Г.Нарангэрэл
Сүхбаатар дүүрэг ХЭДС					
1	"Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг ганцаарчилсан хэлбэрээр 800 иргэнд үзүүлэх" үйлчилгээг гүйцэтгүүлэх 2020/001 дугаартай гэрээт ажилд гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцоогүй 9,600.0 мянган төгрөгийг олгосон.	9.6	Албан шаардлага	ТШЗ, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	М.Отгонтуяа, Т.Оюунгэрэл, Н.Ууганбаяр, Ц.Тунгалаг
2	"Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг ганцаарчилсан хэлбэрээр 800 иргэнд үзүүлэх үйлчилгээ" холбогдох баримт, горим сорилоор нотлогдоогүй	3.3	Төлбөрийн акт	ТШЗ, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	М.Отгонтуяа, Т.Оюунгэрэл, Н.Ууганбаяр, Ц.Тунгалаг
3	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд санхүүгийн эргэн төлөлттэй дэмжлэг авсан иргэдээс авах авлагын үлдэгдлийг	49.6	Зөвлөмж	ТШЗ, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	М.Отгонтуяа, Т.Оюунгэрэл

	барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.				
4	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаагүй.	-	Зөвлөмж	ТШЗ, ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн	М.Отгонтуяа, Т.Оюунгэрэл
	Сонгинохайрхан дүүрэг ХЭДС				
1	2020 оны 3 дугаар сард Хүүхэд хамгаалал төсөлд хамрагдан ажилласан 22 иргэний урамшууллын хөлсийг 1.2 дугаар сард ажилласнаар илүү олгосон	11.2	Төлбөрийн акт	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
2	Алтан алхам ТББ-д 5 иргэнийг ажилд зуучилсан нь баримтаар нотлогдоогүй	2.1	Төлбөрийн акт	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
3	Эргэн төлөлтийн авлагын дансны үлдэгдэл оны эхнээс өссөн ба тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2015-2018 оны эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 366 хүний авлага барагдаагүй.	181.0	Албан шаардлага	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
4	Засгийн газрын тусгай сан ХЭДС-гийн хөрөнгийг арилжааны банк Төрийн банкинд байршуулсан.	-	Албан шаардлага	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
5	Төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдэд мөнгийг шилжүүлэхдээ төлбөрийн хүсэлтийн хавсралтын дагуу биш, өөр хөтөлбөрийн иргэдэд хөтөлбөр хооронд 112,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээ хийсэн.	112.0	Зөвлөмж	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
6	Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 63 мэдээллийг хугацаанд нь, 42 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 44 мэдээллийг байршуулаагүй.	-	Зөвлөмж	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
7	Хүүхэд хамгаалал төслийн 5 дугаар сарын ажлын хөлсийг урьдчилж шилжүүлсэн ба уг төсөлд хамрагдсан иргэдийн 10,735.0 мянган төгрөгийн санхүүжилт Төрийн банкаар дамжиж, цаг тухайдаа иргэдийн дансанд ороогүй, өөр бусдын дансанд шилжсэн.	10.7	Зөвлөмж	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
8	ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөрт хамрагдсан зарим иргэдийн 22,000.0 мянган төгрөгийн санхүүжилт Төрийн банкаар дамжиж, цаг тухайдаа иргэдийн дансанд ороогүй, өөр бусдын дансанд шилжсэн.	22.0	Зөвлөмж	Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн	Э.Энхтуул, Ц.Ууганжаргал
	Хан-Уул дүүрэг ХЭДС				
1	2017 онд 24 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэг олгогдсоноос төлөгдөх хугацаа хэтэрсэн 40,710.9 мянган төгрөгийн 37 иргэнд холбогдох авлагатай тайлагнагдсан.	40.7	Зөвлөмж	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Б.Бадамсүрэн, Б.Болорцэцэг
2	Шилэн дансны цахим хуудсанд 30 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	-	Зөвлөмж	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Б.Бадамсүрэн, Б.Болорцэцэг
	Багануур дүүрэг ХЭДС				
1	2015-2018 онуудад үүссэн он дамжсан нийт 725,050.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй.	94.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Ичинхорлоо, Ш.Зулзаяа
2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийсэн алдаа зөрчил	5.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Ичинхорлоо, Ш.Зулзаяа
	Багахангай дүүрэг ХЭДС				
1	Шилэн дансны цахим хуудсанд 154 мэдээллээс 11 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцруулан байршуулсан байна.	-	Зөвлөмж	нягтлан бодогч	Б.Болорцэцэг
	Налайх дүүрэг ХЭДС				

1	Өмнөх аудитаар эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах, иргэдтэй байгуулсан эргэн төлөгдөх дэмжлэгийн гэрээг санхүүгийн баримтад хавсаргаж байх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй ..	17.3	Албан шаардлага	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Т.Эрдэнэчимэг, Ц.Бямбацэцэг
2	Өмнөх жилүүдэд олгосон эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 42 иргэний 50,479.9 мянган төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн байна.	50.5	Зөвлөмж	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Т.Эрдэнэчимэг, Ц.Бямбацэцэг
3	Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа оруулсан 78, хугацаа хоцроосон 56, огт оруулаагүй 2 мэдээлэл байна. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын нийт 609,161.5 мянган төгрөгийн гүйлгээг шилэн дансанд тухай бүр оруулаагүй байна.	-	Албан шаардлага	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Т.Эрдэнэчимэг, Ц.Бямбацэцэг
4	Нийт 100,103.9 мянган төгрөгийн худалдан авалтаас 63,342.9 мянган төгрөгийн худалдан авалт и-баримт системд ороогүй байна.	63.3	Зөвлөмж	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Т.Эрдэнэчимэг, Ц.Бямбацэцэг
ХБХХЕГазар, ХЭДС					
1	ebaгimt.mn цахим баримтын систем-ийн 158.1 сая төгрөгийн и баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 21.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.	21.0	Зөвлөмж	ерөнхий нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хэрэгжүүлж дэмжлэг авсан "Тахир дутуу иргэдийг дэмжих эрхэм чанар холбоо"ТББ нь хөтөлбөрийн шалгаруулалтад 2019 онд үйл ажиллагаа явуулаагүй байгууллага шалгаруулсан байна.	-	Зөвлөмж	дэд дарга	Д.Ганболд
3	Төсөл хэрэгжүүлж дэмжлэг авсан "Тахир дутуу иргэдийг дэмжих эрхэм чанар холбоо" ТББ-ын ажлын байр, төслийн үр нөлөөг үзэхэд НДШ-ийг тасралтгүй төлөөгүй зөрчил илэрсэн.	-	Зөвлөмж	Бодлогын хэрэгжилтийн газрын дарга	У.Сосорбурам
4	Төсөл хэрэгжүүлж дэмжлэг авсан аж ахуйн нэгж байгууллага 2019, 2020 онуудад гэрээний үүргээ биелүүлж эргэн төлөлт хийгдээгүй КОВИД 19 цар тахлаас шалтгаалан хойшлогдсон		Зөвлөмж	Нягтлан бодогч, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	Б.Баасандолгор, Ч.Цэвэлмаа
Нийт дүн		27,390.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 07 № 515/АО160060
САН-2021/17/СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХЭДС-ийн харьяа зарим байгууллагуудын нягтлан бодогчид нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, зарчмыг баримтлаагүйгээс, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайлан хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, зарчмыг баримталж ажиллаагүй нягтлан бодогч нарт хариуцлага тооцож, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Санхүү төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР  Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 07 № 514/А0160060
СМТ-2021/17/СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 5066 мэдээллээс 4383 мэдээллийг хугацаанд нь, 605 мэдээллийг хугацаа хоцроож, 78 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь байршуулж, биелэлтийг 2021 оны 9 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Санхүү төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Д.ЦЭРЭНДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 07 № 516/А0160060
САГ-2021/17/СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХЭДС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалын 1.2-т "Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан /цаашид төсвийн ерөнхийлөн захирагч гэх/ гаргахад УСНББОУС-6 "Нэгтгэсэн тайлан болон тусдаа санхүүгийн тайлан гэсэн стандарт болон энэхүү журмыг мөрдөнө", 2.3-т "Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр /мянга, сая төгрөгөөр/ илэрхийлэгдсэн байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланг алдаатай бэлтгэсэн ХЭДС-ийн нэгтгэл хариуцсан ажилтанд хариуцлага тооцож, биелэлтийг 2021 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Санхүү төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 07 № 517/АО160060
САГ-2021/17/СТА-317С

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гадаад иргэдийн ажлын байрны төлбөр 26,266.4 сая төгрөгийн орлого орж, 1,823.3 сая төгрөгийн гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн буцаалт хийгдсэн байна. Гадаад ажиллах хүч, мэргэжилтэн авах хэлтсийн ажлын байрын төлбөрийн орлогын бүртгэл, буцаалтад тавих хяналт хангалтгүй, “ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцааг зохицуулах үйлчилгээний бүртгэл мэдээлэл”-ийн программ хангамжийн шинэчлэл удаашралтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын байрын төлбөрийн орлогын бүртгэл, буцаалтад тавих хяналтыг сайжруулж, программ хангамжийн шинэчлэлийг яаралтай дуусган бүрэн ашиглаж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Санхүү төлөвлөлтийн газрын дарга Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Д.ЦЭРЭНДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines for writing.

